



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
НИЙСЛЭЛИЙН АУДИТЫН ГАЗАР

14191 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
8 дугаар хороо, Ж.Лхагвасүрэнгийн гудамж,  
Нийслэлийн засаг захиргааны 5 дугаар байр,  
Утас: 32-77-34, Факс: (976-11) 32 01-54,  
E-mail: ub@audit.gov.mn; http://www.audit.mn


2016.03.04 № 286  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН  
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГА БӨГӨӨД АЖЛЫН  
АЛБАНЫ ДАРГА Ц.АЛТАНЦАЦРАЛ  
ТАНАА

Санхүүгийн тайлангийн аудитын гэрчилгээ,  
аудитыг дуусгавар болгосон тухай тайланг хүргүүлж  
байна.

Хавсралт 27 хуудас

ДЭД ДАРГА



Я.САМБУУНЯМ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
НИЙСЛЭЛИЙН АУДИТЫН ГАЗАР

14191 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
8 дугаар хороо, Ж.Лхагвасүрэнгийн гудамж,  
Нийслэлийн засаг захиргааны 5 дугаар байр,  
Утас: 32-77-34, Факс: (976-11) 32-01-54,  
E-mail: ub@audit.gov.mn; http://www.city.audit.mn

2016.02.04

№

285

танай

-ны №

-т

АУДИТЫН ГЭРЧИЛГЭЭ

Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон, аккруэл сууриар бэлтгэгдсэн, жилийн эцсийн санхүүгийн тайланд Төрийн аудитын тухай хуулийн 15.1.1-д заасан бүрэн эрхийн дагуу Нийслэлийн аудитын газраас аудит хийв.

Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын удирдлага нь тайлант хугацааны санхүүгийн тайланг холбогдох хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу үнэн зөв бэлтгэж, тайлагнах үүрэг, хариуцлага хүлээнэ.

Нийслэлийн аудитын газар нь Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2015 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, санал дүгнэлт өгөх үүрэг, хариуцлага хүлээнэ.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Нийслэлийн аудитын газар аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журам нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2015 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, гол хууль тогтоомжуудын мөрдөлтийг болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит санхүүгийн тайлан материаллаг алдаагүй эсэхэд санал дүгнэлт өгөх хангалттай бөгөөд зохистой үндэслэлийг бүрдүүлсэн болно.

1110400285

### Зөрчилгүй санал дүгнэлт

Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



Ц.ОЧИРБАТ



## ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2015 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл  
дараах хаягаар харилцана уу:

**Я.Самбууням**

Нийслэлийн аудитын газрын дэд  
дарга  
өрөөний утас: 327744

**Д.Энхдалай**

Санхүүгийн аудитын I албаны  
Менежер  
өрөөний утас: 315558

**Д.Жаргалсайхан**

Багийн ахлах аудитор  
өрөөний утас: 325093

### Аудитын тайлан

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Менежментийн захидал

Хавсралт 3: Байгууллагаас ирүүлсэн хариу бичиг

Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Хавсралт 5: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

**ТАБ-ын хаяг:** Нийслэлийн  
аудитын газар

**Байршил:** Улаанбаатар хот  
Сүхбаатар дүүрэг,  
Ж.Лхагвасүрэнгийн гудамж,  
Нийслэлийн засаг захиргааны V байр  
**E mail:** [ub@audit.mn](mailto:ub@audit.mn)

**Манай вэб:** [www.city.audit.mn](http://www.city.audit.mn)

**Цахим хvvdас:** [www.audit.mn](http://www.audit.mn)



## АГУУЛГА

---

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
8. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
9. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
10. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
11. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
12. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
13. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
14. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
15. Зөвлөмж
16. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

**Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:**

Төсвийн тухай хуулийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15.2.1, 18.2 дүгээр зүйлд заасан Нийслэлийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд /НАГ-2016/436/СТА-ТШЗ/ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн, Төрийн аудитын, Нягтлан бодох бүртгэлийн, Төрийн болон орон нутгийн өмчийн, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэв.

Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2015 оны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн Сангийн яамнаас гаргасан заавар, журам, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан Сангийн сайдын холбогдох журмууд, системийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Нийслэлийн аудитын газрын үүрэг юм.

Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2015 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2016 оны 2 дугаар сарын 5-наас 2016 оны 2 дугаар сарын 08-ны хооронд хийхээр төлөвлөн Нийслэлийн аудитын газрын Санхүүгийн аудитын I албаны I багийн ахлах аудитор Д.Жаргалсайхан 2015 оны 2 дугаар сарын 20-25-ны хооронд хийж гүйцэтгэв.

Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2015 оны санхүүгийн тайланг 2016 оны 1 дүгээр сарын 25-нд Нийслэлийн аудитын газарт ирүүлсэн.

Аудитын тайлан, гэрчилгээг 2015 оны 3 дугаар сарын 03-нд Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын удирдлагад хүргүүлж байна.

**Байгууллагын хууль, эрх зүйн орчин:**

Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төсвийн захирагч нь Төсвийн, Нягтлан бодох бүртгэлийн, Төрийн болон орон нутгийн өмчийн, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулиуд болон холбогдох тогтоол, шийдвэр, журам, зааврын хүрээнд үйл ажиллагаа явуулсан байна. Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хуулиудад болон түүнд нийцүүлэн гарсан зарим журам, зааварт өөрчлөлт ороогүй байна.

**Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлд зааснаар ” дүүргийн Хурал нь тухайн нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн болон зохион байгуулалтын ямар ч асуудлыг хэлэлцэж бие даан шийдвэрлэх эрхтэй байдаг.” гэж энэ байгууллагын үйл ажиллагааны зорилтыг тодорхойлсон байна.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16.1-д “төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна” заалтын дагуу Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга төсвийн захирагчийн үүргийг гүйцэтгэж байна.

Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2015 оны төсвийн санхүүжилтийг дүүргийн Төрийн сангаас олгож байна.

Төсвийн шууд захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

**Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим , түүний үр дүн**

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2015 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс байгууллагын удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд уламжлалт болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/



Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил 15-ыг гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад 2008 онд боловсруулсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөн ажилласан байна. Энэхүү бүртгэлийн бодлогын баримт бичиг нь нягтлан бодох бүртгэлийн програмтай уялдсан бөгөөд УСНББОУС-тай нийцсэн байна. Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Засгийн газрын зарим холбогдох тогтоолд өөрчлөлт шинэчлэгдсэнтэй холбогдуулсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт оруулж боловсруулах, хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ гарсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон заавар, журмын дагуу хэрэгжүүлж, СТС ХХК-ийн "СТС" санхүүгийн програмаар боловсруулан санхүүгийн тайланг гаргасан байна.

#### **Дотоод хяналт:**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын дотоод хяналт эрсдэлийг төлөвлөлтийн үед бага гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт зарим талаар хангалтгүй байна.

#### **Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:**

2015 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу дүүргийн Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төсвийн захирагч нь 2015 онд орон төсвөөс урсгал зардалд 1,642,656.8 мянга, нэмэлт санхүүжилтээр 41,005.9 мянга, нийт 1,683,662.7 мянган төгрөгийн санхүүжилт авсан бөгөөд батлагдсан төсвийг бүрэн зарцуулсан байна.



### **Шилэн дансны мэдээлэл**

Шилэн дансны тухай хуулийн дагуу 2015 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн өөрийн байгууллагын цахим хуудас болон шилэн дансны нэгдсэн shilendans.gov.mn цахим хуудсанд 2015 оны төсвийн хуваарь, түүний гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлт, дараа жилийн төсвийн төсөл, тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ, санхүүгийн тайлан (*Хагас жилээр*), таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг зэрэг мэдээллийг байршуулсан байна.

Харин 2014 оны аудит хийгдсэн санхүүгийн тайланг цахим хуудсанд байршуулаагүй байв. Завсарын аудит хийх хугацаанд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж гарсан зөрчил, дутагдлыг арилгаж ажиллах албан шаардлага хүргүүлж хэрэгжилтийг нь гаргуулсан.

### **Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:**

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 39 эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 20 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Бараа материалын нэр төрлөөр нь ангилж бүртгээгүй, үндсэн хөрөнгийг бүртгэлд авалгүй шууд зардалд бүртгэсэн, дансны бичилт буруу хийсэн, НДШ-ийн тооцоо буруу илэрхийлсэн зэрэг зөрчлүүд нь санхүүгийн тайлангийн оршин байх, хамааралтай байх, иж бүрэн байх, хэмжилт, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Эдгээр эрсдлүүд нь төсвийг үр ашиггүй зарцуулж зардал өсгөх, тайлан мэдээ буруу гаргах, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхгүй зөрчдөг зэрэг сөрөг үр дагаварт хүрч болзошгүй байна.

### **Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар:**

Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2015 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний 100.0 мянган төгрөгөөс дээш /мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, бараа материал, бусад орлого, цалин хөлс бичиг хэрэг, тээвэр шатахуун/ дүн бүхий ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Эдгээр шалгасан нарийвчилсан сорил нь тус байгууллагын нийт орлогын 98.7 хувь, нийт зардлын 98.0 хувийг тус тус эзэлж байна.

**Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг  
шийдвэрлэсэн талаар:**

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад материаллаг бус хэмжээний 4,986.0 мянган төгрөгийн зөрчил илэрлээ .Үүнд:

1. Бараа материалыг нэр төрлөөр тулгаж үзэхэд 202.0 мянган төгрөгийн дардасыг ангилал буруу бүртгэсэн нь Сангийн сайдын 388 дугаар тушаалын 4.1 "Бараа материалыг ангилж бүртгэхдээ дансны нэгдсэн жагсаалт болон холбогдох УСНББОУС-г мөрдөнө " заалтыг зөрчсөн байна.
  - **Шийдвэрлэсэн:** Санхүүгийн тайланд залруулга хийлгүүлэв. Бараа материалыг ангиллын дагуу үнэн зөв бүртгэж байх, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлснийг тус байгууллага хүлээн зөвшөөрч цаашид зөрчлийг давтан гаргахгүй анхаарч ажиллах талаар хариу ирүүлсэн.
2. Үндсэн хөрөнгийг нэр төрлөөр тулган шалгахад 275.0 мянган төгрөгийн нярвын програмыг биет бус хөрөнгөд бүртгэлгүй зардлаар тайлагнасан нь УСНББОУС-17-ийн 26 "хөрөнгө гэж хүлээн зөвшөөрөгдөх шалгуурыг хангаж буй үндсэн хөрөнгийн зүйлийг анхны удаа өртгөөр нь хэмжинэ" 9.1. "Аж ахуйн нэгж, байгууллага нь хөрөнгө, өр төлбөрөө нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэлж дансанд тусгана" заалтуудтай нийцэхгүй байна.
  - **Шийдвэрлэсэн:** Санхүүгийн тайланд залруулга хийлгүүлэв. Хөрөнгийг ангиллын дагуу үнэн зөв бүртгэж, хөрөнгөнд тавих дотоод хяналтыг сайжруулах, цаашид энэхүү алдааг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлснийг тус байгууллага хүлээн зөвшөөрч цаашид зөрчлийг давтан гаргахгүй анхаарч ажиллах талаар хариу ирүүлсэн.
3. Нийгмийн даатгалын шимтгэлийн дутуу төлөлт 435.7 мянган төгрөгийн өглөгийг санхүүгийн тайланд тусгаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.2. "санхүүгийн тайлан нь үнэн, зөв баримт материал, бодит тоо, мэдээнд үндэслэх", 9.1. "Аж ахуйн нэгж, байгууллага нь хөрөнгө, өр төлбөрөө нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэлж дансанд тусгана" гэсэн заалтыг тус тус зөрчиж байна.
  - **Шийдвэрлэсэн:** Санхүүгийн тайланд залруулга хийлгүүлэв. Нийгмийн даатгалын шимтгэлийг үнэн зөв гаргаж, тооцооны үлдэгдлийг актаар баталгаажуулж байх, цаашид энэхүү алдааг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлснийг тус байгууллага хүлээн зөвшөөрч цаашид зөрчлийг давтан гаргахгүй анхаарч ажиллах талаар хариу ирүүлсэн.



4. Ажиллагсдын цалингаас 451.9 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл дутуу тооцсон нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 15.1 “Энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2, 4 дэх хэсэгт заасан даатгуулагч болон ажил олгогч нь дор дурдсан хувь хэмжээгээр сар бүр нийгмийн даатгалын шимтгэл төлнө.”, 16.1 “Ажил олгогч нь даатгуулагчийн төлбөр зохих нийгмийн даатгалын шимтгэлийг түүнд хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого олгох бүртээ энэ хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан хувь хэмжээгээр тооцон суутгаж, тухайн сард нь багтаан нийгмийн даатгалын сангийн дансанд шилжүүлнэ” заалтыг зөрчсөн байна.
  - Шийдвэрлэсэн: Дутуу тооцсон шимтгэлийг холбогдох хүмүүсээр нөхөн төлүүлж Нийгмийн даатгалын санд төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоосныг тус байгууллага хүлээн зөвшөөрч цаашид зөрчлийг давтан гаргахгүй анхаарч ажиллах талаар хариу ирүүлсэн.
5. Ажилчин, албан хаагчдын цалингаас 103.4 мянган төгрөгийн ХХОАТ илүү суутгасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.2. “санхүүгийн тайлан нь үнэн, зөв баримт материал, бодит тоо, мэдээнд үндэслэх” гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.
  - Шийдвэрлэсэн: Татвар, нийгмийн даатгалын шимтгэлийг үнэн зөв тооцож байх, цаашид энэхүү алдааг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлснийг тус байгууллага хүлээн зөвшөөрч цаашид зөрчлийг давтан гаргахгүй анхаарч ажиллах талаар хариу ирүүлсэн.
6. Цалингаас шийтгэл 328.7 мянга, цагийн хоцрогдол 195.5 мянга, нийт 524.2 мянган төгрөг суутган тооцсон боловч цалингийн зардлыг бууруулж дансны бичилт буруу хийсэн нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар 3 дах зүйлийн Зардал хэсгийн ажиллагчидтай холбогдох зардлын бүртгэл 3.6 б-д “байгууллага олговол зохих цалингаас суутган төлөх төлбөрийг тооцож бусад өглөгт шилжүүлэн бүртгэнэ” заалтыг зөрчсөн байна.
  - Шийдвэрлэсэн: Дансны бичилтийг холбогдох заавар журамд нийцүүлэн зөв хийх, цаашид энэхүү алдааг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлснийг тус байгууллага хүлээн зөвшөөрч цаашид зөрчлийг давтан гаргахгүй анхаарч ажиллах талаар хариу ирүүлсэн.
7. Цалингийн хүснэгтээр бодогдсон цалингийн дүнгээс үр дүнгийн тайлангийн цалингийн зардал 2,878.8 мянган төгрөгөөр дутуу илэрхийлэгдсэн нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын 3.6.б “Байгууллага олговол зохих цалингаас суутган төлөх

төлбөрийг тооцож, бусад өглөгт шилжүүлэн бүртгэнэ” заалтыг зөрчсөн байна.

- **Шийдвэрлэсэн:** Цалингийн зардлыг анхан шатны баримтанд үндэслэн үнэн зөв тайлагнаж байх, цаашид энэхүү алдааг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлснийг тус байгууллага хүлээн зөвшөөрч цаашид зөрчлийг давтан гаргахгүй анхаарч ажиллах талаар хариу ирүүлсэн.

8. Урьдчилж төлсөн шуудан холбооны зардал 115.0 мянган төгрөгийг зардалд шууд тусгасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйл. Нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт 13.1"Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" гэсэн заалтыг зөрчсөн байна.

- **Шийдвэрлэсэн:** Санхүүгийн тайланд залруулга хийлгүүлэв. Төлбөр тооцоог үнэн зөв гаргаж, тооцооны үлдэгдлийг актаар баталгаажуулж байх, цаашид энэхүү алдааг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлснийг тус байгууллага хүлээн зөвшөөрч цаашид зөрчлийг давтан гаргахгүй анхаарч ажиллах талаар хариу ирүүлсэн.

#### **Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:**

Санхүүгийн тайланд илэрсэн хууль, журам, заавар мөрдөөгүйгээс шалтгаалан гарсан 976.1 мянган төгрөгийн алдааг залруулах боломжгүй бөгөөд цаашид давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

#### **Анхаарал татахуйц бусад чухал асуудал:**

Бараа материал, үндсэн хөрөнгийг орлогод авахдаа ангиллын дагуу бүртгэлд тусгаж байх шаардлагатай байна.

#### **Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:**

Тухайн аудитын хамрах хүрээний асуудал боловч 2015 онд тавьж олгосон цаг хугацааны байдлаас шалтгаалж аудитын явцад цалингийн тооцооллыг давтан хийгээгүй нь эрсдэлтэй байж болох тул завсрын аудитаар шалгахаар тогтов.

#### **Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:**

Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2015 оны оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 4,986.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн ба үүнээс 4,009.9 мянган төгрөгийг алдааг санхүүгийн тайланд залруулуулж,



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2015 ОНЫ  
ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

524.2 мянган төгрөгийн зөрчилд давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлж, 451.9 мянган төгрөгийн зөрчилд төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

**Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:**

Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2014 оны санхүүгийн тайлангийн аудитаар Чингэлтэй дүүргийн орон нутгийн төсвийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хамрагдсан бөгөөд тусгайлан бие даасан зөвлөмж хүргүүлээгүй болно.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

Аудитлагдсан санхүүгийн тайлан 8 хуудас, хавсралтууд 5 хуудас, байгууллагын санал 1 хуудсыг тус тус хавсаргав.

**АУДИТЫН ТАЙЛАНГ**

**ХЯНАСАН:**

ДЭД ДАРГА



Я.САМБУУНЯМ

АУДИТЫН МЕНЕЖЕР



Д.ЭНХДАЛАЙ

**БЭЛТГЭСЭН:**

АХЛАХ АУДИТОР



Д.ЖАРГАЛСАЙХАН

2016.03.02



## ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2015 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл  
дараах хаягаар харилцана уу:

Нийслэлийн аудитын газрын  
дэд дарга Я.Самбууням  
өрөөний утас: 327734

Д.Энхдалай  
Санхүүгийн аудитын  
I албаны Менежер  
өрөөний утас: 315558

Д.Жаргалсайхан  
Багийн ахлах аудитор

ТАБ-ын хаяг: Нийслэлийн  
аудитын газар  
**Байршил:** Улаанбаатар хот  
Сүхбаатар дүүрэг,  
Ж.Лхагвасүрэнгийн гудамж,  
Нийслэлийн засаг захиргааны V байр  
**E mail:** [ub@audit.mn](mailto:ub@audit.mn)

Манай вэб: [www.city.audit.mn](http://www.city.audit.mn)

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

### Менежментийн захидал

Тэргүүлэх ач холбогдол №2 зүйлс:  
Асуудал 1

Бараа материал .....	3
Асуудал 2	
Үндсэн хөрөнгө .....	3-4
Асуудал 3	
Өглөг .....	4
Асуудал 4	
Цалин .....	4-5
Асуудал 5	
Зардал .....	6

2016 оны 2 дугаар сар 25

### **Менежментийн захидал**

Нийслэлийн аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг Чингэлтэй дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг ТАБ-ын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Нийслэлийн аудитын газрын энэхүү зөвлөмж нь та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Чингэлтэй дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын санхүүгийн холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## Асуудал 1: Бараа материал

### НАГ-ын ажиглалт

Бараа материалыг нэр төрлөөр тулгаж үзэхэд 202.0 мянган төгрөгийн дардасыг ангилал буруу бүртгэсэн нь Сангийн сайдын 388 дугаар тушаалын 4.1 "Бараа материалыг ангилж бүртгэхдээ дансны нэгдсэн жагсаалт болон холбогдох УСНББОУС-г мөрдөнө" заалтыг зөрчсөн байна.

### Эрсдэлүүд

Бараа материалын үлдэгдэл буруу илэрхийлэгдэх;

## Тэргүүлэх ач олбогдол №2

### НАГ-ын зөвлөмж

Бараа материалыг ангиллын дагуу үнэн зөв бүртгэж байх;

### Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрч цаашид зөрчлийг давтан гаргахгүй ажиллах талаар 2016.02.26-ны өдрийн 2/64 тоот албан бичгээр хариу ирүүлсэн болно.

## Асуудал 2: Үндсэн хөрөнгө

### НАГ-ын ажиглалт

1. Үндсэн хөрөнгийг нэр төрлөөр тулган шалгахад 275.0 мянган төгрөгийн нярвын програмыг биет бус хөрөнгөд бүртгэлгүй шууд зардлаар тайлагнасан нь УСНББОУС-17-ийн 26 "хөрөнгө гэж хүлээн зөвшөөрөгдөх шалгуурыг хангаж буй үндсэн хөрөнгийн зүйлийг анхны удаа өртгөөр нь хэмжинэ" 9.1. "Аж ахуйн нэгж, байгууллага нь хөрөнгө, өр төлбөрөө нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэлж дансанд тусгана" заалтуудтай нийцэхгүй байна.

### Эрсдэлүүд

- Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх; Үндсэн хөрөнгийн үлдэгдэл буруу илэрхийлэгдэх;

## Тэргүүлэх ач холбогдол №2

### НАГ-ын зөвлөмж

- Хөрөнгийг ангиллын дагуу үнэн зөв бүртгэж байх;
- Хөрөнгөнд тавих дотоод хяналтыг сайжруулах;

### Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрч цаашид зөрчлийг давтан гаргахгүй ажиллах талаар



2016.02.26-ны өдрийн 2/64 тоот  
албан бичгээр хариу ирүүлсэн  
болно

### Асуудал 3: Өглөг

#### НАГ-ын ажиглалт

1. Нийгмийн даатгалын шимтгэлийн дутуу төлөлт 435.7 мянган төгрөгийн өглөгийг санхүүгийн тайланд тусгаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.2. "санхүүгийн тайлан нь үнэн, зөв баримт материал, бодит тоо, мэдээнд үндэслэх", 9.1. "Аж ахуйн нэгж, байгууллага нь хөрөнгө, өр төлбөрөө нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэлж дансанд тусгана" гэсэн заалтыг тус тус зөрчиж байна

#### Эрсдэлүүд

- Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх;  
Үндсэн хөрөнгийн үлдэгдэл буруу илэрхийлэгдэх;

### Асуудал 4: Цалин

#### НАГ-ын ажиглалт

1. Ажиллагсдын цалингаас 451.9 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл дутуу тооцсон нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 15.1 "Энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2, 4 дэх хэсэгт заасан даатгуулагч болон ажил олгогч нь дор дурдсан хувь хэмжээгээр сар бүр нийгмийн даатгалын шимтгэл төлнө:", 16.1 "Ажил олгогч нь даатгуулагчийн төлбөр зохих нийгмийн даатгалын шимтгэлийг түүнд хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого

### Тэргүүлэх ач холбогдол №2

#### НАГ-ын зөвлөмж

- Нийгмийн даатгалын шимтгэлийг үнэн зөв гаргаж, тооцооны үлдэгдлийг актаар баталгаажуулж байх;

#### Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрч цаашид зөрчлийг давтан гаргахгүй ажиллах талаар 2016.02.26-ны өдрийн 2/64 тоот албан бичгээр хариу ирүүлсэн болно.

### Тэргүүлэх ач холбогдол №2

#### НАГ-ын зөвлөмж

- Татвар, нийгмийн даатгалын шимтгэлийг үнэн зөв тооцож байх;

олгох бүртээ энэ хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан хувь хэмжээгээр тооцон суутгаж, тухайн сард нь багтаан нийгмийн даатгалын сангийн дансанд шилжүүлнэ” заалтыг зөрчсөн байна.

2. Ажилчин, албан хаагчдын цалингаас 103.4 мянган төгрөгийн ХХОАТ илүү суутгасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.2. “санхүүгийн тайлан нь үнэн, зөв баримт материал, бодит тоо, мэдээнд үндэслэх” гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

3. Цалингаас шийтгэл 328.7 мянга, цагийн хоцрогдол 195.5 мянга, нийт 524.2 мянган төгрөг суутган тооцсон боловч цалингийн зардлыг бууруулж дансны бичилт буруу хийсэн нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар 3 дах зүйлийн Зардал хэсгийн ажиллагчидтай холбогдох зардлын бүртгэл 3.6 б-д “байгууллага олговол зохих цалингаас суутган төлөх төлбөрийг тооцож бусад өглөгт шилжүүлэн бүртгэнэ” заалтыг зөрчсөн байна.

4. Цалингийн хүснэгтээр бодогдсон цалингийн дүнгээс үр дүнгийн тайлангийн цалингийн зардал 2,878.8 мянган төгрөгөөр дутуу илэрхийлэгдсэн нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын 3.6.б “Байгууллага олговол зохих цалингаас суутган төлөх төлбөрийг тооцож, бусад өглөгт шилжүүлэн бүртгэнэ” заалтыг зөрчсөн байна.

- Дансны бичилтийг холбогдох заавар журамд нийцүүлэн зөв хийх;

- Цалингийн зардлыг анхан шатны баримтанд үндэслэн үнэн зөв тайлагнаж байх;

#### Эрсдэлүүд

- Татвар, нийгмийн даатгалын шимтгэлийг буруу, зөрүүтэй тооцох;  
Хууль, журам, заавар хэрэгжихгүй байх

#### Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрч цаашид зөрчлийг давтан гаргахгүй ажиллах талаар 2016.02.26-ны өдрийн 2/64 тоот албан бичгээр хариу ирүүлсэн болно.

**Асуудал 5: Зардал**

**НАГ-ын ажиглалт**

5. Урьдчилж төлсөн шуудан холбооны зардал 115.0 мянган төгрөгийг зардалд шууд тусгасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйл. Нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт 13.1. *Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*” гэсэн заалтыг зөрчсөн байна.

**Эрсдэлүүд**

- Санхүүгийн илэрхийлэгдэрх;

тайлан

буруу

**Тэргүүлэх ач холбогдол №2**

**НАГ-ын зөвлөмж**

- Төлбөр тооцоог үнэн зөв гаргаж байх;

**Төсвийн захирагчийн хариу**

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрч цаашид зөрчлийг давтан гаргахгүй ажиллах талаар 2016.02.26-ны өдрийн 2/64 тоот албан бичгээр хариу ирүүлсэн болно.

**МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДЛЫГ**

**ХЯНАСАН:**

ДЭД ДАРГА



Я.САМБУУНЯМ

2016.02.25

АУДИТЫН МЕНЕЖЕР



Д.ЭНХДАЛАЙ

2016.02.25

**БЭЛТГЭСЭН:**

АХЛАХ АУДИТОР



Д.ЖАРГАЛСАЙХАН

2016.02.25



*Ж. Самбуугийн*  
*Ж. Самбуугийн*  
10/1



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРАЛ

15170 Улаанбаатар хот,  
Чингэлтэй дүүрэг, Ж.Самбуугийн гудамж 16,  
Утас: 31-31-93, 31-10-48, Факс: (976-11) 31-01-94

2016.02.26 № 4/04

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

НИЙСЛЭЛИЙН АУДИТЫН ГАЗАР

Нийслэлийн аудитын газраас тус дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2015 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг баталгаажуулах аудит хийж, зөрчлийн тухай ирүүлсэн менежментийн захидалтай танилцлаа.

Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын санхүүгийн бүртгэл, тайлагналд гарсан зөрчлүүдийг хүлээн зөвшөөрч байгаа бөгөөд цаашид Нийслэлийн аудитын газраас өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж, өмнө гаргасан зөрчлөө давтан гаргахгүйн төлөө ажиллах болно.

АЖЛЫН АЛБАНЫ  
ДАРГА

ЦАЛТАНЦАЦРАЛ



1150100139



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2015 ОНЫ  
ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>45,603,113.00</b>	<b>42,386,547.00</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	5,975,638.00	3,369,472.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	869,472.00
<b>33500</b>	<b>Бусад авлага</b>	5,975,638.00	2,500,000.00
33510	Байгууллагаас авах авлага	5,975,638.00	2,500,000.00
<b>34</b>	<b>УРЬДЧИЛГАА</b>	-	114,950.00
34600	Урьдчилж гарсан зардал	-	114,950.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	39,579,475.00	38,854,125.00
<b>35400</b>	<b>Хангамжийн материал</b>	39,579,475.00	38,854,125.00
35410	Бичиг хэргийн материал	1,155,150.00	2,058,400.00
35420	Аж ахуйн материал	3,026,795.00	2,983,795.00
35430	Сэлбэг хэрэгсэл	967,000.00	3,207,000.00
35470	Бусад хангамжийн материал	34,430,530.00	30,604,930.00
<b>36</b>	<b>НӨӨЦИЙН БАРАА</b>	48,000.00	48,000.00
36100	Барааны нөөц	48,000.00	48,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>324,414,694.14</b>	<b>255,286,841.34</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	324,414,694.14	255,286,841.34
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>	315,205,694.22	245,993,091.31
39203	Авто-тээврийн хэрэгсэл	128,056,000.00	130,780,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(27,843,566.57)	(40,334,133.17)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	218,986,760.81	172,640,210.81
39206	Хуримтлагдсан элэгдэл	(72,562,379.10)	(96,965,233.85)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	88,144,035.46	108,529,935.46
39208	Хуримтлагдсан элэгдэл	(19,575,156.38)	(28,657,687.94)
<b>39300</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	9,208,999.92	9,293,750.03
39301	Програм хангамж	120,000.00	395,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(36,000.00)	(101,249.97)
39303	Бусад биет бус хөрөнгө	10,207,000.00	10,207,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(1,082,000.08)	(1,207,000.00)
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>370,017,807.14</b>	<b>297,673,388.34</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>4,569,742.00</b>	<b>3,491,000.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	4,569,742.00	3,491,000.00
<b>41300</b>	<b>Өглөг</b>	4,569,742.00	3,491,000.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	991,000.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	2,069,742.00	-

**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2015 ОНЫ  
ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

<b>41360</b>	<b>Бусад өглөг</b>	2,500,000.00	2,500,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	2,500,000.00	2,500,000.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>365,448,065.14</b>	<b>294,182,388.34</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	365,448,065.14	294,182,388.34
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	646,476,498.00	646,476,498.00
51101	Өмч: төрийн	646,476,498.00	646,476,498.00
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	(261,186,113.65)	(332,451,790.45)
51210	Өмнөх үеийн үр дүн	(400,028,898.60)	(261,186,113.65)
51220	Тайлант үеийн үр дүн	138,842,784.95	(71,265,676.80)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	(19,842,319.21)	(19,842,319.21)
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>370,017,807.14</b>	<b>297,673,388.34</b>

**АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН**

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,622,542,600.00</b>	<b>1,683,389,544.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>50,600,000.00</b>	<b>1,132,744.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	50,600,000.00	1,132,744.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	50,600,000.00	1,132,744.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	250,000.00	1,132,744.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	50,350,000.00	-
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,571,942,600.00</b>	<b>1,682,256,800.00</b>
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	1,571,942,600.00	1,682,256,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,545,942,600.00	1,642,656,800.00
132005	Хөрөнгийн санхүүжилт / орон нутгийн төсөвт байгууллага/	26,000,000.00	39,600,000.00
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,482,763,808.76</b>	<b>1,702,037,020.80</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,482,763,808.76</b>	<b>1,702,037,020.80</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	642,714,988.76	1,560,590,620.80
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	400,769,094.42	522,219,528.00
210101	Үндсэн цалин	207,623,486.42	283,556,028.00
210102	Нэмэгдэл	119,709,432.00	145,119,500.00
210105	Гэрээт ажлын хөлс	73,436,176.00	93,544,000.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	45,372,800.00	57,597,700.00
210201	Тэтгэврийн даатгал	28,873,599.36	36,811,519.20



**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ХУРЛЫН 2015 ОНЫ  
ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

210202	Тэтгэмжийн даатгал	3,299,839.13	4,732,398.35
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,124,800.91	4,621,383.45
210204	Ажилгүйдлийн даатгал	824,959.78	1,039,308.08
210205	Эрүүл мэндийн даатгал	8,249,600.82	10,393,090.92
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>37,533,148.89</b>	<b>43,916,168.00</b>
210401	Бичиг хэрэг	9,638,725.29	9,084,832.00
210402	Тээвэр, шатахуун	10,378,110.00	10,615,186.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,162,413.60	17,585,050.00
210404	Ном, хэвлэл	8,252,400.00	2,398,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,101,500.00	4,233,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,257,758.00</b>	<b>916,000.00</b>
210604	Урсгал засвар	1,257,758.00	916,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>15,441,040.00</b>	<b>11,606,679.00</b>
210701	Гадаад албан томилолт	12,817,040.00	3,790,980.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	2,624,000.00	7,815,699.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>14,387,755.00</b>	<b>9,625,000.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,156,000.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,425,130.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,806,625.00	895,000.00
210813	Бусад зардал	6,000,000.00	8,730,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>127,953,392.45</b>	<b>914,709,545.80</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	87,004,870.00	868,197,543.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	40,948,522.45	46,512,002.80
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>840,048,820.00</b>	<b>141,446,400.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>840,048,820.00</b>	<b>141,446,400.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	840,048,820.00	141,446,400.00
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b><u>139,778,791.24</u></b>	<b><u>(18,647,476.80)</u></b>
<b>V</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>936,006.29</b>	<b>52,618,200.00</b>
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	936,006.29	52,618,200.00
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b><u>138,842,784.95</u></b>	<b><u>(71,265,676.80)</u></b>



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2015 ОНЫ  
ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

**АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b><u>1,603,749,925.89</u></b>	<b><u>1,683,662,696.00</u></b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>31,807,325.89</b>	-
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	31,807,325.89	-
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	31,807,325.89	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	31,807,325.89	-
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,571,942,600.00</b>	<b>1,683,662,696.00</b>
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>1,571,942,600.00</b>	<b>1,683,662,696.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,545,942,600.00	1,642,656,800.00
132005	Хөрөнгийн санхүүжилт / орон нутгийн төсөвт байгууллага/	26,000,000.00	41,005,896.00
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b><u>1,503,594,746.89</u></b>	<b><u>1,653,660,346.00</u></b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,503,594,746.89</b>	<b>1,653,660,346.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>647,155,630.89</b>	<b>1,508,024,746.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>401,134,642.00</b>	<b>519,654,900.00</b>
210101	Үндсэн цалин	207,989,034.00	280,991,400.00
210102	Нэмэгдэл	119,709,432.00	145,119,500.00
210105	Гэрээт ажлын хөлс	73,436,176.00	93,544,000.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>45,372,800.00</b>	<b>57,162,000.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	28,873,599.36	36,375,819.20
210202	Тэтгэмжийн даатгал	3,299,839.13	4,732,398.35
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,124,800.91	4,621,383.45
210204	Ажилгүйдлийн даатгал	824,959.78	1,039,308.08
210205	Эрүүл мэндийн даатгал	8,249,600.82	10,393,090.92
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>38,804,098.89</b>	<b>45,365,918.00</b>
210401	Бичиг хэрэг	10,793,875.29	9,645,432.00
210402	Тээвэр, шатахуун	10,378,110.00	10,615,186.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,162,413.60	17,700,000.00
210404	Ном, хэвлэл	8,267,400.00	2,398,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,202,300.00	5,007,200.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>43,825,785.00</b>	<b>3,236,000.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	34,688,000.00	80,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	4,446,000.00	-

**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2015 ОНЫ  
ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

210604	Урсгал засвар	4,691,785.00	3,156,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>15,441,040.00</b>	<b>11,606,679.00</b>
210701	Гадаад албан томилолт	12,817,040.00	3,790,980.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	2,624,000.00	7,815,699.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>12,261,595.00</b>	<b>895,000.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,969,840.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,485,130.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,806,625.00	895,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>90,315,670.00</b>	<b>870,104,249.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	90,315,670.00	870,104,249.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>856,439,116.00</b>	<b>145,635,600.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>855,033,220.00</b>	<b>145,635,600.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	855,033,220.00	145,635,600.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>1,405,896.00</b>	<b>-</b>
213401	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт төсөвт байгууллага	1,405,896.00	-
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b><u>100,155,179.00</u></b>	<b><u>30,002,350.00</u></b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>102,295,870.00</b>	<b>30,002,350.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>102,295,870.00</b>	<b>30,002,350.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>102,295,870.00</b>	<b>30,002,350.00</b>
225101	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	102,295,870.00	30,002,350.00
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b><u>(102,295,870.00)</u></b>	<b><u>(30,002,350.00)</u></b>
<b>VIII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>(2,140,691.00)</b>	<b>-</b>
<b>X</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>(2,140,691.00)</b>	<b>-</b>



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2015 ОНЫ  
ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
<b>2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	646,476,498.00	3,356,680.79	(423,227,898.60)		226,605,280.19
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	(23,199,000.00)	23,199,000.00		-
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>646,476,498.00</b>	<b>(19,842,319.21)</b>	<b>(400,028,898.60)</b>	-	226,605,280.19
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-		-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-		-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-		-
Тайлант үеийн үр дүн	-	-	138,842,784.95		138,842,784.95
<b>2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>646,476,498.00</b>	<b>(19,842,319.21)</b>	<b>(261,186,113.65)</b>	-	365,448,065.14
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-		-
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	-	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-		-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-		-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-		-
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-		-
Тайлант үеийн үр дүн	-	-	(71,265,676.80)		(71,265,676.80)
<b>2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>646,476,498.00</b>	<b>(19,842,319.21)</b>	<b>(332,451,790.45)</b>	-	294,182,388.34



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2015 ОНЫ  
ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Хөтөлбөрийн код	Зориулалт, арга хэмжээний код	ЭЗ Ангилал 2015	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
70101	80101	II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,642,656,800.00	1,642,656,800.00	-	0.00
70101	80101	21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,642,656,800.00	1,642,656,800.00	-	0.00
70101	80101	210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,642,656,800.00	1,642,656,800.00	-	0.00
70101	80101	2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	519,654,900.00	519,654,900.00	-	0.00
70101	80101	210101	Үндсэн цалин	340,116,900.00	340,116,900.00	-	0.00
70101	80101	210103	Унаа хоолны хөнгөлөлт	85,994,000.00	85,994,000.00	-	0.00
70101	80101	210105	Гэрээт ажлын хөлс	93,544,000.00	93,544,000.00	-	0.00
70101	80101	2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	57,162,000.00	57,162,000.00	-	0.00
70101	80101	210201	Тэтгэврийн даатгал	37,064,600.00	36,375,819.20	(688,780.80)	-1.86
70101	80101	210202	Тэтгэмжийн даатгал	4,019,500.00	4,732,398.35	712,898.35	17.74
70101	80101	210203	ҮОМШӨ-ний даатгал	5,024,300.00	4,621,383.45	(402,916.55)	-8.02
70101	80101	210204	Ажилгүйдлийн даатгал	1,004,900.00	1,039,308.08	34,408.08	3.42
70101	80101	210205	Эрүүл мэндийн даатгал	10,048,700.00	10,393,090.92	344,390.92	3.43
70101	80101	2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	8,730,000.00	8,730,000.00	-	0.00
70101	80101	210304	Байрны түрээс	8,730,000.00	8,730,000.00	-	0.00
70101	80101	2104	Хангамж, бараа материалын зардал	40,358,700.00	40,358,718.00	18.00	0.00
70101	80101	210401	Бичиг хэрэг	9,645,400.00	9,645,432.00	32.00	0.00
70101	80101	210402	Тээвэр, шатахуун	10,615,200.00	10,615,186.00	(14.00)	0.00
70101	80101	210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	17,700,000.00	17,700,000.00	-	0.00
70101	80101	210404	Ном, хэвлэл	2,398,100.00	2,398,100.00	-	0.00
70101	80101	2105	Нормативт зардал	29,807,400.00	29,807,350.00	(50.00)	0.00
70101	80101	210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	29,807,400.00	29,807,350.00	(50.00)	0.00
70101	80101	2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,163,200.00	8,163,200.00	-	0.00
70101	80101	210601	Багаж, техник, хэрэгсэл	5,007,200.00	5,007,200.00	-	0.00
70101	80101	210604	Урсгал засвар	3,156,000.00	3,156,000.00	-	0.00
70101	80101	2107	Томилолт, зочны зардал	11,606,700.00	11,606,679.00	(21.00)	0.00

**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2015 ОНЫ  
ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

70101	80101	210701	Гадаад албан томилолт	3,791,000.00	3,790,980.00	(20.00)	0.00
70101	80101	210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	7,815,700.00	7,815,699.00	(1.00)	0.00
70101	80101	<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	748,487,500.00	748,487,533.00	33.00	0.00
70101	80101	210804	Тээврийн хэрэгслийн татвар	747,592,500.00	747,592,533.00	33.00	0.00
70101	80101	210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	895,000.00	895,000.00	-	0.00
70101	80101	<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	218,686,400.00	218,686,420.00	20.00	0.00
70101	80101	210901	Бараа үйлчилгээний бусад зардал	153,405,600.00	153,405,600.00	-	0.00
70101	80101	210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	65,280,800.00	65,280,820.00	20.00	0.00
70101	80101	<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	1,642,656,800.00	1,642,656,800.00	-	0.00
70101	80101	<b>31</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	1,642,656,800.00	1,642,656,800.00	-	0.00
70101	80101	310001	Улсын төсвөөс санхүүжих	1,642,656,800.00	1,642,656,800.00	-	0.00
70101	80101	<b>6</b>	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	43.00	43.00	-	0.00
70101	80101	<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	1.00	1.00	-	0.00
70101	80101	610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	-	0.00
70101	80101	<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	42.00	42.00	-	0.00
70101	80101	620001	Удирдах ажилтан	2.00	2.00	-	0.00
70101	80101	620002	Гүйцэтгэх ажилтан	34.00	34.00	-	0.00
70101	80101	620003	Үйлчлэх ажилтан	6.00	6.00	-	0.00